

ХӨТӨЛБӨРИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

1. Сургалт явуулж ирсэн түүхэн замнал, туршлага:

Монгол улсад орчин цагийн мэргэжлийн боловсон хүчин, үүний дотор багшлах боловсон хүчнийг бэлтгэж эхэлсэн эрдмийн их өргөө Багшийн сургууль 1922 онд байгуулагдсан билээ.

Багшийн сургуулиас Монголын нэртэй эрдэмтэн мэргэд, сэхээтнүүд, улс төрийн зүтгэлтэн, урлаг, спорт, боловсролын салбарын алдартнууд, хөдөлмөрийн баатрууд, ардын болон гавьяат цолтон, төрийн соёрхолт зэрэг бидний бахархан дуурайх үе үеийн шилдгүүд олноор төрөн гарсан.

Багшийн сургууль байгуулагдсан цаг үеэс эхлэн, өөрийн дэргэд янз бүрийн хугацаатай 30-аад төрлийн курс, дугуйлан, анги, зун, өвлийн түр сургууль, мэргэжилтэн бэлтгэх курс, салбаруудыг улс орны нийгмийн хэрэгцээ шаардлагын дагуу үүсэн байгуулж, хөгжүүлж ирсэн түүхтэй.




Монгол орныхоо өнцөг булан бүрд соёлын үрийг тарьж, улс орныхоо хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулсны нэг тод жишээ нь 1962 оноос Улаанбаатар хотын Багшийн сургуулийн дэргэд “Дуу хөгжмийн багшийн анги”-ийг нээснээр, “Дуу хөгжмийн мэргэжлийн багш” бэлтгэх эхлэл суурь болсон байна.

БНМАУ-ын Гэгээрлийн Яамны Сайд, Соёлын Яамны сайдын 1962 оны 1-р сарын 11-ний өдрийн № 12/3 хамтарсан тушаалаар Улаанбаатар хотын Багшийн сургуулийн дэргэд Хөгжим-дууны багш нарыг бэлтгэх ангийг байгуулахаар шийдвэрлэсэн байна. Уг тушаалын 1-

р заалтад “1961 оны улсын төлөвлөгөө ёсоор Улаанбаатар хотын Багшийн сургуулийн дэргэд хөгжим-дууны багш нарыг бэлтгэх ангийг 1962 оны 2-р сарын 1-ээс 30 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж хичээллүүлэхийг Улаанбаатар хотын Багшийн сургуулийн захирал Д.Гомбосүрэнд даалгасугай” хэмээсэн байна.

Улмаар БНМАУ-ын Гэгээрлийн Яамны Сайдын 1962 оны 7-р сарын 3-ны өдрийн №198 тоот тушаалаар Улаанбаатар хот дахь Багшийн сургуульд дуу хөгжмийн багшаар Москва хотын хөгжмийн дунд сургууль төгссөн Дамбийнямын Жанчивыг томилжээ. Тэрээр тус сургуульд хөгжмийн онол, гармони, утга зохиол, найрал дуу, найруулга зүй, соноршуулга зэрэг мэргэжлийн бүх л суурь хичээлийг заадаг байжээ.

БНМАУ-ын ГЯ-ны Сайдын 1963 оны 6-р сарын 21-ний өдрийн №204 тоот тушаалаар “Сурган хүмүүжүүлэх ухааны Зөвлөлийн дуу хөгжмийн салбар”-ыг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсны дотор тус зөвлөлийн бүрэлдэхүүнд Багшийн сургуулийн багш Д.Жанчив, Б.Намжилмаа нар багтсан байна.



БНМАУ-ын Соёлын Яамны сайдын 1969 оны 1-р сарын 4-ний өдрийн № Б/7 тушаалаар “Үндэсний дуу, бүжиг, хөгжмийн багш, удирдаач бэлтгэх анги”- ийг Улсын Багшийн Дээд Сургуульд нээн хичээллүүлж эхэлжээ.

Багш бэлтгэх сургуулийн хөгжмийн ангид үзэх хичээлийн программ /хөтөлбөр/-ыг батлагдсан төлөвлөгөөний дагуу Багшийн сургуулийн хөгжмийн багш нар боловсруулан, БНМАУ-ын Соёлын яам, Ардын боловсролын яамны Арга зүйн хэлтэс, СХУ-ны Хүрээлэнгийн мэргэжилтнүүдээр хэлэлцүүлэн өгсөн зөвлөмжийн дагуу засан сайжруулж, эцэст АБЯ-ны

Агуулга, арга зүй, эрдмийн зөвлөлийн Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулдаг нарийн тогтолцоотой байжээ. Тухайлбал, БНМАУ-ын Соёлын яамнаас 1979 оны 7-р сарын 13-нд “Ардын боловсролын яамны арга зүйн хэлтэст” хаягласан № 2/1189 тоот албан бичигт: “Улаанбаатар хотын Багш нарыг бэлтгэх сургуулийн хөгжмийн ангид үзэх хөгжмийн утга зохиол, найрал дууны судлал, аранжировка, хөгжмийн онол, ёочин, сольфеджио, найрал дуу, удирдахуй, морин хуур, хоолой тавилт, шудрага, ятга, бүжиг, гармони, хуучир, төгөлдөр хуур зэрэг 16 хичээлийн программыг мэргэжлийн хүмүүст үзүүлж, засвар зөвлөмж өгүүлэн засуулав. Эдгээр программын дагуу сургалт явуулахад татгалзах зүйлгүй болохыг мэдэгдье. Уран бүтээлийн хэлтсийн дарга Д.Жанчив” гэсэн байна.

БНМАУ-ын Боловсролын яамны сайдын 1991 оны 12-р сарын 2-ны өдрийн №477 тоот тушаалаар Багшийн коллежийн Хөгжмийн салбар болон Цэцэрлэгийн багшийн коллежийн Хөгжмийн ангийг нэгтгэн, Хөгжмийн багшийн коллеж болгон, 1992 оны 1-р сарын 1-нээс зохион байгуулж, Улсын Багшийн Их Сургуулийн харьяанд ажиллуулахаар шийдвэрлэжээ. Хөгжмийн багшийн коллежийн захирлаар Дашнямын Нарантуяаг томилон ажиллуулсан байна.



Монгол Улсын Шинжлэх ухаан, боловсролын сайдын 1995 оны 10-р сарын 24-ний өдрийн №260 тоот тушаалаар, бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлттэй холбоотойгоор УБИС-ийн харьяа Цэцэрлэгийн болон Хөгжмийн багшийн коллежийг татан буулгаж, Сурган хүмүүжүүлэх ухааны коллежийг байгуулан, түүний дэргэд Хөгжмийн факультетийг

байгуулжээ. Улмаар Гэгээрлийн сайдын 1998 оны 5-р сарын 20-ны өдрийн 119 дүгээр тушаалаар УБИС-ийн Сурган Хүмүүжүүлэх Ухааны коллежийн хөгжмийн факультетийг Соёлын коллежид шилжүүлсэн байна.

БСШУЯ-наас олгосон 2015 оны 06-р сарын 03-ны 960016 дугаар тусгай зөвшөөрөл, МУБИС-ийн Хөтөлбөрийн хорооны хөтөлбөр шинэчлэн батлах тухай 2015 оны А/1, А/2, А/3 тоот хурлын шийдвэрийг тус тус үндэслэн, МУБИС-ийн захирлын 2015 оны 08-р сарын 31-ний өдрийн А/165 тоот тушаалаар “Багш, урлагийн боловсрол - Хөгжмийн багш-(индекс 011404)-ийн ангийг нээн төлөвлөгөө, стандарт, хөтөлбөрийг боловсруулан, шинээр элсэлт авч эхэлжээ.

МУБИС-ийн Удирдах зөвлөлийн 2017 оны 08-р сарын 28-ны өдрийн 06 тоот тогтоолыг үндэслэн, МУБИС-ийн бүтцийн өөрчлөлттэй уялдуулан, “Урлаг, биеийн тамирын сургууль”-д харьяалагдаж байсан “Дуу хөгжмийн багш”-ийн ангийг “Багшийн сургууль”-д шилжүүлснээр, анх 1962 онд Багшийн сургуулийн дэргэд үүсэн байгуулагдсан “Дуу хөгжмийн багш бэлтгэх” анги нь дахин Багшийн сургуульдаа ийнхүү шилжин ирсэн түүхтэй.

Багшийн сургуулийн хөгжмийн багшийн салбарын төгсөгчид нь зөвхөн сайн багш төдийгүй Монголын хөгжмийн нэртэй зүтгэлтнүүд болж, улс орныхоо урлаг соёлын хөгжлийг өндөрт өргөж яваа гавьяатнууд билээ. Үүнд: МУ-ын Хөдөлмөрийн баатар, Ардын жүжигчин, Төрийн хошой шагналт, доктор, профессор Н.Жанцанноров, МУ-ын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, УГЗ Б.Шарав, Төрийн шагналт Ц.Нацагдорж, Х.Билэгжаргал, Ц.Чинзориг, УГЗ, З.Батсүх, Ч.Сангидорж, Б.Бямбабаяр, Т.Сэр-Од болон Д.Чойбаатар, С.Тараа, С.Батболд, Х.Баатар, Д.Дэнсмаа, Г.Магсаржав, Бат-Эрдэнэ, Т.Хатанбаатар, С.Мөнхбат, П.Ганбат, Н.Баасандорж, Д.Сүхбаатар нарын олон арван хөгжмийн зохиолчид цөм энэ сургуулиар урлах эрдэм заалгаж, ур ухаанаа нээж ирсэн байх юм. Дээр дурдсан багш, хөгжмийн зохиолчдоос гадна МУ-ын урлаг, соёлын бусад салбарт ажиллаж, нэр алдраа ард түмнийхээ дунд цуурайтуулсан олон алдартан бий. Тухайлбал, МУ-ын Гавьяат багш Б.Найдан, Г.Бадам, Х.Баасанцэрэн, Ш.Баттогоо, эрдэмтэн судлаач С.Отголжий, Ц.Цовоо, Ц.Баттуяа, Ш.Цогтгэрэл, Гавьяат жүжигчин Ч.Туул, Ж.Жавзмаа, Х.Болормаа, Д.Ширмэнтуйа нарыг төлөөлүүлэн дурдаж болно.

Багшийн сургуулийн хөгжмийн ангид анх 1962 онд элсэгчид авч, 1965 онд дунд сургуулийн дуу хөгжмийн анхны тусгай дунд боловсролтой багш нарыг төгсгөсөн байна. Түүнээс хойш 1998 он хүртэл 33 төгсөлтөөр нийт 900 гаруй хүнийг бэлтгэн гаргажээ. 2018-2025 оны байдлаар нийт 251 оюутанг төгсгөжээ.

Хөтөлбөрийг анх баталж, сургалт явуулж эхэлсэн огноо: 1962-1998 он, 2015 оноос өнөөг хүртэл:

Хөтөлбөрөөр суралцагчдын тоо: /Тухайн хичээлийн жилээр/

Суралцагчийн түвшин	Суралцагчдын тоо
1-р курс	50
2-р курс	34
3-р курс	33
4-р курс	31
5-р курс	
6-р курс	
Нийт	148

Хөтөлбөрөөр элсэгч, төгсөгчийн тоо: /Сүүлийн 3-5 жилээр/

Хичээлийн жил	Элсэгчийн тоо	Төгсөгчийн тоо
2020-2021 хичээлийн жил	58	39
2021-2022 хичээлийн жил	73	52
2022-2023 хичээлийн жил	31	24
2023-2024 хичээлийн жил	46	25
2024-2025 хичээлийн жил	54	28
Нийт	262	168

Хөтөлбөр хэрэгжүүлэгч хөгжмийн үндсэн багш нарын мэдээлэл:

№	Овог, нэр	Албан тушаал	Мэргэжлийн чиглэл /мэргэшил/	Боловсролын зэрэг
1	Ч.Отгонбаяр	Тэнхимийн эрхлэгч /ахлах багш/	Хөгжмийн багш	Доктор (Ph.D)
2	Ц.Эрдэнэтуяа	Ахлах багш	Хөгжмийн багш	Доктор (Ph.D)
3	Г.Заяабат	Ахлах багш	Хөгжмийн багш	Доктор (Ph.D)
4	Д.Батсүх	Багш	Хөгжмийн багш	Магистр
5	О.Шинэбаяр	Багш	Хөгжмийн багш	Магистр
6	Х.Бархүү	Багш	Хөгжмийн багш	Магистр
7	Л.Баяраа	Багш	Хөгжмийн багш	Магистр
8	Б.Өсөхбаяр	Багш	Хөгжмийн багш	Магистр
9	Б.Номинзул	Багш	Хөгжмийн багш	Магистр
10	Хисако Ватанабе	Жайка олон улсын байгууллагын сайн дурын ажилтан, багш	Хөгжмийн багш	Магистр

Хөтөлбөрийг шинэчилж, боловсронгуй болгосон байдал:

№	Өөрчлөлт орсон огноо	Өмнөх индекс, хөтөлбөрийн нэр	Өөрчлөгдсөн индекс, хөтөлбөрийн нэр
1	2021	D011404 Багш, урлагийн боловсрол	D011404 Багш, урлагийн

		хөтөлбөрийн Хөгжмийн багш бэлтгэх хөтөлбөр	боловсрол
2	2024	D011404 Багш, урлагийн боловсрол	D011424, Багш, хөгжмийн боловсрол
...			

Багшийн сургуулийн магадлан итгэмжлүүлсэн бакалаврын хөтөлбөрүүдийн талаарх мэдээлэл:

№	Хөтөлбөрийн нэр, индекс	Огноо	Тогтоолын дугаар	Шийдвэр /Магадлан итгэмжлэгдсэн; нөхцөлтэй магадлан итгэмжлэгдсэн; магадлан итгэмжлэхийг түдгэлзсэн/
1	Бага боловсролын багш	2009.06.02	№ 29	5 жилээр магадлан итгэмжлэгдсэн
2	Багш, бага ангийн боловсрол /D011301/	2018.06.20	№ 09	5 жилээр магадлан итгэмжлэгдсэн
3	Багш, урлагийн боловсрол /D011404/	2020.05.28	№ 03	5 жилээр магадлан итгэмжлэгдсэн
4	Бага боловсрол /011302/	2024.09.18	2024/01-36	5 жилээр магадлан итгэмжлэгдсэн
5	Teacher, Primary Education /D011301/ РТЕР	2024.09.20	N.37800285-240232-1	2030.09.30 хүртэл ACQUIN-ээр магадлан итгэмжлэгдсэн.

МУБИС-ийн Багшийн сургуулийн захирлын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/08 дугаар тушаалаар “Багш, хөгжмийн боловсрол” бакалаврын сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх ажлын хэсэг байгуулагдав.

“Багш, хөгжмийн боловсрол” магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний багийн ахлагчийн талаарх мэдээлэл:

Овог, нэр: Цэвээндашийн Дэлгэрсайхан
Албан тушаал: дэд профессор, доктор (Sc.D)
Харилцах утас: 99079867
Цахим шуудан: delgersaikhan@msue.edu.mn

Хөтөлбөрийг хэрэгжүүлдэг үндсэн нэгжийн байршил, утас, цахим шуудангийн хаяг:

МУБИС-ийн Багшийн сургууль, V байр. Өргөтгөл. otgonbayar.ch@msue.edu.mn